

# ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

*А. Ундраа*

*“Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрийн 4 курсын оюутан  
Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль  
aundra1006@gmail.com*

*Д. Одмаа*

*Доктор (Ph. D.), дэд профессор  
Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль  
odmaadanga@gmail.com*

**Хураангуй:** Боловсролын зээлийн сангаас олгодог оюутны хөгжлийн зээл нь оюутан суралцагчийн сурах бололцоог нэмэгдүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилготой олгогдож эхэлсэн. Тус зээл нь суралцах чин хүсэлтэй ч ар гэрийн бололцоо хомс байдлаас үүдэн сургууль завсарддаг, өрийн дарамтад орсон олон оюутан залууст суралцах боломж, ирээдүйнх нь итгэл болдог байсан. Цар тахлын болоод бусад нөхцөл байдлын улмаас 2021 оны төсөвт тусгагдсан оюутны хөгжлийн зээлийн санхүүжилт танагдаж, улмаар зээл олгох журамд өөрчлөлт орсон. Ингэхдээ “Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжил” эзэмшиж буй оюутан суралцагчдад зээлийг олгох шийдвэр гарсан. Үүний улмаас олон оюутан суралцагчид мэргэжил сонголт болон санхүүгийн бололцоогүйгээсээ болж их, дээд сургуульд суралцах боломжгүй болж байна. Түүнчлэн тэд ирээдүйд ажилгүйчүүдийн эгнээ рүү шилжих аюул нүүрлээд байгаа учраас оюутны хөгжлийн зээлийн хэрэгцээ шаардлагыг судалсан болно.

**Түлхүүр үгс:** Боловсрол, суралцагч, суралцах хэрэгцээ, сургалтын төлбөр, шийдвэр

## I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Монгол улсад 1993 оноос оюутан суралцагчийн сурах бололцоог нэмэгдүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийг зорин “Сургалтын төрийн сан”-г байгуулсан ба 2016 оноос эхлэн Боловсролын Зээлийн сан болон шинэчлэгдсэн. Тус сангийн үйл ажиллагаа нь дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцагч оюутанд хөгжлийн зээл олгох, нийгмийн зорилтот бүлгийн суралцагчдад сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж үзүүлэх чиглэлтэй. 2018 оны 05 сарын 01-нийг хүртэл оюутны хөгжлийн зээлийг барьцаа хөрөнгө, хүүтэйгээр олгож байсан бол тус журамд өөрчлөлт орон барьцаагүй, хүүгүй, урт хугацааны зээл болгон өөрчилсөн юм. Энэ нь олон оюутан суралцагчдад суралцах хэрэгцээгээ хангах боломж олгосон сайн шийдвэр байсан хэдий ч удаан үргэлжлээгүй. Засгийн газрын 2020 оны 02

сарын 19-ний өдрийн 70-р тогтоолоор “тэргүүлэх ач холбогдолтой, нэн хэрэгцээтэй мэргэжлийн чиглэл”-ийн мэргэжил сонгон суралцаж буй оюутан суралцагчдад Боловсролын зээлийн сангаас оюутны хөгжлийн зээл олгох шийдвэр гарснаар мэргэжил сонголтоороо ялгаварлан гадуурхагдаж олон оюутны эрх ашиг зөрчигдөх болсон. Иймд сургалтын төлбөр төлөх боломжгүй оюутнуудын зээлийн хэрэгцээг тодорхойлох, үүнээс үүсэх сөрөг үр дагаврыг илрүүлэх зорилгоор уг илтгэлийг бичсэн болно. Судалгаанд баримт бичгийн болон анкетийн аргыг ашигласан. Тоон судалгааг Google forms ашиглан онлайнаар 400 оролцогчоос нээлттэйгээр авсан. Цаашид оюутны хөгжлийн зээлийг хэрхэн оновчтой олгох, хэрхэн үр ашигтай зарцуулах талаар судалгааны үр дүнд үндэслэн санал дэвшүүлсэн.

## II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

*“Боловсрол бол өөртөө итгэх итгэлтэй болгодог. Өөртөө итгэлтэй байх нь хүсэл, найдварыг төрүүлдэг. Хүсэл мөрөөдөлтэй байх нь энх тайвныг дэлгэрүүлдэг”* гэж Хятадын философич Күнз хэлсэн байдаг. 1996 оны Делорийн илтгэлд тусгагдсан чухал үзэл баримтлалуудын нэг бол суралцах үйл ажиллагааны дөрвөн тулгуур зарчим буюу *“Мэдэхийн тулд суралцах, Хийж чадахын тулд суралцах, Хүн болохын тулд суралцах, Хамт амьдрахад суралцах* явдал юм гэжээ [1]. Дэлхий даяар бүх нийтийн сурах боломжийг өргөжүүлэх тал дээр асар их дэвшил гарч, энэ чиглэл рүү улс орнууд анхаарлаа хандуулж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн даяаршил улс орны дотоодод болон улс орнуудын хооронд тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна. Боловсролын системүүд эмзэг бүлгийн болон ядуу амьдарч буй суралцагчдын боловсролын хэрэгцээг үл хайхрахын зэрэгцээ хүн амын чинээлэг давхаргынхны боловсрол олох боломжид анхаарлаа хандуулж, дээд зэргийн чанартай боловсролын хүртээмжийг хэт явцуу хүрээнд олгох болсноос тэгш бус байдлыг улам тэлж байна [2]. Боловсролд гадуурхалт үүсэх уламжлалт хүчин зүйл болох жендэр, хот, хөдөөгийн ялгаа зэрэг нь орлого, хэл, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлсээр хүрээгээ тэлж, ялангуяа орлогын түвшин доогуур ядуу буурай улс орнуудын иргэдэд хүндээр тусч байна.

Хүнд биологийн хэрэгцээнээс гадна илүү нарийн хэрэгцээнүүд бий болдог. А.Маслоугийн хэрэгцээний шатлалын онол ёсоор хүний хэрэгцээг *“Физиологийн хэрэгцээ, аюулгүй байдлын хэрэгцээ, нийгмийн буюу харилцааны хэрэгцээ, хүндэтгүүлэх хэрэгцээ, өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ”* [3] гэсэн 5 шатлалд оруулан пирамид хэлбэрээр тодорхойлсон байдаг. Харин тэдгээр хэрэгцээ нь биелэгдээд эхлэхэд дахиад түүнээс илүү нарийн хэрэгцээ шаардлагатай болж эхэлнэ.” Судлаачид А.Маслоугийн хэрэгцээний шатлалын

онолыг баяжуулж, “*Физиологийн, аюулгүй байдлын, харьяалагдах ба хайрлах, хүндлэгдэх, танин мэдэхүйн, гоо зүйн, өөрийгөө илэрхийлэх, бусдын төлөө гэх хэрэгцээ*”-ний 8 шатлал бүхий шинэчилсэн загварыг боловсруулсан байдаг [4]. Түүнчлэн судлаач Клейтон Алдерфер түүний онолыг шинэчлэн “ERG онол” [5]-ыг боловсруулсан. ERG онолоор хүний хэрэгцээг 3 бүлэг болгон ангилдаг. Үүнд:

1. Оршин тогтнох хэрэгцээ-Эрүүл саруул, эд хөрөнгөтэй байх хэрэгцээ
2. Харилцаатай байх хэрэгцээ-Бусадтай сайн харилцаатай байх хэрэгцээ
3. Өсч хөгжих хэрэгцээ-Мэдлэг чадвараа өргөжүүлэх, суралцах хэрэгцээ [6] тус тус орно.

Эндээс үзвэл хүний зайлшгүй нэг хэрэгцээ нь суралцах хэрэгцээ юм. Учир нь бид өөрсдийгөө гадны нөлөөллөөс хамгаалах, өөрийгөө илэрхийлэх, хооллох, хувцаслах гээд физиологийн болоод аюулгүй байдлын хэрэгцээгээ хангаж чадаж байгаа учраас удаах хэрэгцээ болох нийгэмд хамаарагдах, тэднээр өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх үүднээс мэдлэг, чадварыг өөртөө хуримтлуулж суралцаж байна гэж ойлгож болох юм. Тэгвэл суралцах хэрэгцээг хангагч гол хүчин зүйл нь сургалтын төлбөр. Хүн бүр өөрийн хэрэгцээг ханган оргилд гарахыг далд ухамсартаа хүсэх боловч сургалтын төлбөргүйгээс үүдэж суралцах хэрэгцээ хангагдаж чадахгүй нөхцөл үүсэж байна. Иймд төрөөс төрийн сангийн зээл буюу Оюутны хөгжлийн зээлийг олгож эхэлсэн. Үүний ачаар оюутан суралцагчид суралцах явцдаа өөртөө итгэх итгэлийн хэрэгцээ улмаар өөрийгөө олох хэрэгцээг бий болгох боломж бүрдэж байсан, цаашид бүрдэх ч болно гэж үзэж байна.

Монгол улс боловсролд хамрагдах түвшний үзүүлэлтээр, ялангуяа залуучуудын хувьд, бүс нутагтаа тэргүүлж байгаа боловч ядуу ба ядуу бус хүн ам боловсролын түвшнээрээ илт ялгаатай байна. Ядуу давхаргын хүмүүсийн ихэнх нь дунд буюу ахлах ангийн боловсролоос цааш суралцаагүй, тэдний арвын нэг нь л дээд боловсролтой байх агаад харин хамгийн өндөр амьжиргааны түвшинтэй 20 хувийн тэн хагас нь дээд боловсролтой байна. [7] Тиймээс орчин үеийн залуучуудад суралцах хэрэгцээ шаардлага байна. Харин үүнийг хангах сургалтын төлбөрийг барагдуулах нь манай улсын дийлэнх өрхийн хувьд тулгамдсан асуудал болоод байна. Улсын хэмжээнд 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт өрхийн 55.0 хувь буюу 499.8 мянган өрх зээлтэй амьдарч байна [8], мөн 3 өрх тутмын нэг нь ядуу өрх байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактад “*Суралцах, боловсрол эзэмших эрх нь хүний бусад бүх эрхийн адил оролцогч улс орнуудад дагаж мөрдөх, хамгаалах, хэрэгжүүлэх гэсэн гурван төрлийн буюу гурван түвшний үүрэг ноогдуулна. Хэрэгжүүлэх үүрэг нь дэм үзүүлэх ба хангах гэсэн хоёр үүргийг хоёуланг хамаарна. Дагаж мөрдөх үүрэг нь боловсрол эзэмших*

эрхээ эдлэхэд саад болох эсвэл бэрхшээл учруулах арга хэмжээ авахаас зайлсхийхийг оролцогч улс орнуудаас шаардана. Хамгаалах үүрэг нь боловсрол эзэмших эрхээ эдлэхэд гуравдагч талууд хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авахыг оролцогч-улсуудаас шаардана. Хэрэгжүүлэх (дэм үзүүлэх) үүрэг нь боловсрол эзэмших эрхээ эдлэхэд хувь хүмүүс, нийгмийн бүлгүүдэд боломж олгож, дэм үзүүлэх зэрэг зэрэг арга хэмжээнүүд авахыг оролцогч улсуудаас шаардана. Эцэст нь, оролцогч-улсууд боловсрол эзэмших эрхийг биелүүлэх (хангах) үүрэгтэй” [9] байдаг гэж заажээ. Гэсэн ч манай улсад энэ байдал хангалттай хэрэгжихгүй байна.

Дээд боловсролын сургалтын шууд ба шууд бус зардал нь хүн амын зарим давхаргын хувьд дээд боловсрол эзэмших боломж, мөн суралцаж чадахгүй байх гол шалтгаан хэвээр байгаагийн дээр боловсролын зээлийн талаар сайн хөтөлбөрүүд өргөн хүрээнд дэлгэрч чадахгүй, туршигдсаар байна [10]. Тухайлбал, **БНХАУ**-ын Төрийн сангийн зээл нь барьцаатай, хамтран зээлдэгчтэй, хүүтэй зээл байдаг. Зээлийн хүү нь эргэн төлөгдөх хугацаанаасаа шалтгаалан 5.04%-5.76%-ийн хүү тооцно. Зээлийн хүүний талыг Засгийн газар, үлдсэн хувийг нь оюутан өөрөө хариуцан төлдөг. Нэг оюутанд ногдох зээлийн дээд хэмжээ 6000 юаниас хэтрэхгүй ба 8 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтөө гүйцэлдүүлэх шаардлагатай. Хятадын Үндэсний нийт сургуулиудын бага коллежийн оюутнууд, өдрийн бакалавр, аспирантур, 2-р зэргийн оюутнууд зээлд хамрагдах боломжтой [11]. **Япон** улсын төрийн сангийн зээл нь шалгуур өндөртэй бөгөөд түүнийг хангасан оюутнуудад зээл өгдөг. Төрийн сангийн зээл нь 13-20 жилийн хугацаатай 0.02%-0.07%-ийн хүүтэй байдаг сард 64000 иен хүртэлх зээлийг олгодог [12]. **БНСУ**-ын төрийн сангийн зээл нь нэг оюутанд 1.5 сая хүртэл вонын зээл олгох ба 1 улирлын 1.7%-ийн хүү тооцно. Зээлийг сургууль төгссөнөөс хойш гэрээ байгуулан сар бүр төлнө. Зээлд бүх түвшний оюутан суралцагч хамрагдах боломжтой ажээ [13].

Манай улсын хувьд боловсролын зээлийн үйлчилгээг анх 1993 оноос нэвтрүүлж, **“Сургалтын төрийн сан”** гэсэн нэртэй байгууллагыг үүсгэн байгуулж байсан. Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор **“Боловсролын зээлийн сан”** болж өөрчлөгдсөн. *Боловсролын зээлийн сан гэдэгт дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах байгууллагыг ойлгоно.* [14] Боловсролын зээлийн сан нь 3 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

Нэгдүгээрт, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан өрхийн суралцагч гэх мэт нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг олгох;

Хоёрдугаарт, гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл болон Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу суралцагчид амьжиргааны тэтгэлэг олгох;

Гуравдугаарт, Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн буюу оюутны хөгжлийн зээлийг олгох гэсэн үйл ажиллагаа ордог.

Дээрх 3 чиглэлийн үйл ажиллагааны нэг нь оюутны хөгжлийн зээл олгох бөгөөд оюутны хөгжлийн зээл гэдэг нь *“Төрийн сангийн зээлээр суралцаж төгссөнөөс зургаа хүртэлх жилийн дотор эргэн төлөх зээл ба хүүгүй, барьцаагүй, урт хугацаатай, хамтран зээлдэгчгүй, бүх шатны суралцагчид авах боломжтой зээл”* юм.

Боловсролын зээлийн сан нь 2018 оныг хүртэл оюутан суралцагчид банкаар дамжуулан хамтран зээлдэгч, барьцаа, хүүтэйгээр зээл олгож байсан бол 2018 оноос эхэлж хүүгүй, хамтран зээлдэгч, барьцаа хөрөнгө шаардахгүйгээр “Боловсролын зээлийн сан”-гаас санхүүжилтийг нь шууд олгож, диплом авсан өдрөөс эхлэн зургаа хүртэлх жилийн дотор зээлээ эргэн төлөх өөрчлөлттэйгөөр журам баталсан.

1993 онд байгуулагдсанаас хойш 880 гаруй тэрбум төгрөг зарцуулсан. Оюутны хөгжлийн зээлд давхардсан тоогоор 1,2 сая суралцагч хамрагдснаас 420 гаруй мянган хүүхэд бүтэн зээлд хамрагдсан байдаг. 2017 оноос хойш 37 мянга гаруй оюутан хамрагдаж, 42 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан гэсэн статистик байна. 2020 онд их, дээд сургууль төгссөн 1971 оюутан, Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр, 2.8-аас дээш голч дүнтэй амжилттай суралцаж байгаа 2782 оюутанд 6.4 тэрбум төгрөгийн зээлийг өнгөрсөн онд олгосон ажээ [15].

*Хүснэгт 1. БЗС-гаас олгодог Оюутны хөгжлийн зээлийн анхны болоод одоогийн нөхцөл*

<b>Хуучин нөхцөл</b>
<b>Зээлдүүлэгч байгууллага</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Арилжааны банк</li> </ul>
<b>Хамрах хүрээ</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Шалгуур хангасан бүх оюутан</li> </ul>
<b>Зээлийн төрөл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Хүү бууруулах зээл</li> <li>• Богино хугацаат зээл</li> <li>• Урт хугацаат зээл</li> </ul>
<b>Зээлийн нөхцөл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Хүү 5% (жилийн)</li> <li>• Богино, урт хугацаатай</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Хамтран зээлдэгчтэй</li> <li>• Барьцаагүй олгодог</li> <li>• Даатгалгүй</li> </ul>
<b>Зээлийн шаардлага</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Элсэгч (ЭЕШ оноо 650+)</li> <li>• Оюутан (голч дүн 3+)</li> <li>• Суралцагч (журмын дагуу элссэн)</li> <li>• Сонгосон хичээлийн төлбөрөөр</li> </ul>
<b>Зээлийн хүсэлт гаргах</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Оршин суух харьяаллын банканд хүсэлт гаргах</li> </ul>
<b>Бүрдүүлэх материал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Зээл хүссэн өргөдөл</li> <li>• Үндсэн хамтран зээлдэгчийн иргэний үнэмлэх</li> <li>• Оюутны үнэмлэх</li> <li>• Сургуульд элссэнийг гэрчлэх батламж</li> <li>• Голч дүнгийн тодорхойлолт</li> <li>• Банкинд төлбөр төлсөн баримтын эх хувь (хүү бууруулах зээлийн хувьд)</li> <li>• Банкны шаардлагын дагуу орлого тодорхойлох баримтууд</li> </ul>

<b>Шинэчлэгдсэн нөхцөл</b>
<b>Зээлдүүлэгч байгууллага</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын Зээлийн Сан</li> </ul>
<b>Хамрах хүрээ</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Монгол улсад тэргүүлэх чиглэлийн мэргэжил эзэмшиж буй оюутан</li> </ul>
<b>Зээлийн төрөл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Оюутны хөгжлийн зээл</li> </ul>
<b>Зээлийн нөхцөл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Хүүгүй</li> <li>• Урт хугацаатай</li> <li>• Хамтран зээлдэгчгүй</li> <li>• Барьцаагүй</li> <li>• Даатгалтай</li> </ul>
<b>Зээлийн шаардлага</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Элсэгч (ЭЕШ оноо 600+)</li> <li>• Оюутан (голч дүн 2.8+)</li> <li>• Суралцагч (голч дүн 3.2+)</li> <li>• Улиралд 10+ кредит сонгох</li> </ul>
<b>Зээлийн хүсэлт гаргах</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн сургуульдаа хүсэлт гаргах</li> </ul>
<b>Бүрдүүлэх материал</b>

- Ирээдүйн зорилгоо тодорхойлох эсээ
- Иргэний үнэмлэхний хуулбар
- ЭЕШ-ын онооны хуудасны хуулбар
- Сургуульд зохих журмын дагуу элссэнийг нотлох баримт
- Сургуулийн тодорхойлолт
- Төлбөрийн нэхэмжлэл
- Тухайн хичээлийн улиралд судлах хичээлүүдийн баталгаажуулсан жагсаалт

2021 онд боловсролын зээлийн санд 31 тэрбум төгрөг батлагдсан боловч 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн “Төсвийн тодотгол”-оор тодотгогдож 7,6 тэрбум болон танагдсан. 2020-2021 оны намрын улирлын хичээлийн жилд тэргүүлэх чиглэлийн мэргэжлээс бусад мэргэжлээр, 2.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа 5028 оюутан Боловсролын зээлийн сангаас зээл авах хүсэлт гаргасан байна. Эдгээр оюутны нийт санхүүжилт нь 8,1 тэрбум төгрөг юм. 2020-2021 оны хаврын улирлын хичээлийн жилд 6635 оюутан шаардлагыг ханган зээлийн хүсэлт гаргасан ба түүнд 9,9 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай болсон. БШУЯ-ны болон Сангийн сайдын хамтарсан А/3408 тушаал 2021 оны 02 дугаар сарын 01-нд гаран хүсэлт гаргасан нийт оюутны санхүүжилт болох 18 тэрбум төгрөгийг олгохоор заасан [16]. Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлээс бусад мэргэжлээр суралцаж байгаа оюутан суралцагчдад энэхүү цар тахлын хүнд нөхцөлд суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаагийн арга хэмжээ болгон сургалтын төлбөрийн зээлийг 2021 оны батлагдсан төсвийн хүрээнд багтаан олгохоор шийдвэр гарсан нь энэ билээ. Энэ нь оюутны хөгжлийн зээлээр суралцдаг, шинээр зээл авахыг хүссэн оюутнууд болон олон нийтийн эсэргүүцлийг намжаасан, гал унтраасан явдал болсон гэж үзэж байна. Цаашид яах эсэх нь өнөөдрийг хүртэл тодорхой бус байна.


### **III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

Энэ хэсэгт ямар сорил, туршилтыг, ямар аргаар, хэрхэн гүйцэтгэсэн, хэчнээн хэмжээний материал, мэдээлэл хуримтлуулж, үр дүнд ямар арга зүйгээр боловсруулалт хийсэн зэргийг дурдана. Монголын их, дээд сургуулийн суралцагчдын оюутны хөгжлийн зээлийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор 2021 оны 03 сарын 15-наас 03 сарын 19-ний хооронд Google forms ашиглан онлайнээр нээлттэй судалгаа авсан. Монгол улсын хэмжээнд 2020 оны байдлаар нийт 147293 суралцагч суралцаж байгаагаас бакалаврын сургалтад 119232 оюутан, ахисан түвшинд 28061 суралцагч суралцаж байна [17]. Судалгааны түүврийн хэмжээ хангалттай эсэхийг [surveymonkey.com](http://surveymonkey.com) [18] тооцоолуур ашиглан тогтоосон бөгөөд 383 оюутан судалгаанд хамрагдахад найдвартай байдлын түвшин 95 хувь, алдааны хязгаар 5 хувь байхаар тооцсон.

Тэгвэл тус судалгаанд 400 оюутан хамрагдсан нь түүврийн хэмжээг бүрэн төлөөлөхийн зэрэгцээ хамрах хүрээ нь төрийн томоохон их сургуулиуд болох МУИС, ШУТИС, МУБИС, АШУУИС, ХААИС, ДХИС, ҮБХИС, СУИС болон орон нутгийн, хувийн хэвшлийн их, дээд сургуулиудын оюутнуудын төлөөлөл байв.

Судалгаанд хамрагдсан оролцогчдын 87.4% нь эмэгтэй, 12,6% нь эрэгтэй байсан бөгөөд насны хувьд 20-22 насныхан дийлэнхийг эзэлж, дараа нь 18-20 насныхан идэвхтэй хамрагдсан байна.

Суралцах түвшний хувьд 98% нь бакалаврын зэргийн оюутан байв. Үүнээс үзэхэд магистр болон докторын түвшний суралцагчид нь бакалаврын түвшний суралцагчдыг бодоход оюутны хөгжлийн зээлд бага хамрагддаг, мөн санхүүгийн хувьд илүү чадамжтай байж болох юм.



Нийт судалгаанд хамрагдсан бакалаврын түвшний оюутнуудын талаас илүү хувь буюу 67.7% нь 3 болон 4-р курсын оюутнууд байгаагаас үзвэл ОХЗ-ийн талаарх мэдээллийг их сургуульд орсноос хойш тодорхой хугацааны дараа олж мэдэх ба мэдээллийн хүртээмжтэй байдал муу нөгөө талаар оюутны голч оноо хүрэхгүй байх зэрэг үзүүлэлт саад болдог байж магадгүй байна. Зээлд хамрагдах оюутнууд курс ахих тусам сайжрах байдал ажиглагдсан. Судалгаанд хамрагдсан нийт оюутан суралцагчдийн 69% нь төрийн өмчийн сургуульд сурдаг байна. Энэ нь төрийн сангаас авсан зээл тэр дороо эргээд төрдөө очиж байгааг илтгэж байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн сарын дундаж орлогыг дүгнэвэл сард 420.000₮-1.000.000₮-ийн хооронд орлого олдог өрх нийт оролцогчдын 84.1%-ийг эзэлж байна. Оюутан суралцагчийн нэг улирлын хичээлийн төлбөр дунджаар 2.000.000 төгрөг байдаг. Тэгвэл тухайн айлд их дээд сургуульд суралцдаг оюутан/суралцагч 1-ээс олон байх тохиолдол олон бий. Хамгийн бага буюу 1 оюутан/суралцагчтай өрх 2-5 сарын турш нийт орлогоо цуглуулсанаар сургалтын төлбөрийг бүрдүүлэх боломж үүсэж байна. Гэвч хүн

бүр физиологийн болоод өөр бусад олон хэрэгцээтэй байдаг. Хэрэгцээгээ хангахын тулд санхүүгийн асуудал тулгарна. Ингээд тухайн өрхийн оюутан суралцах хэрэгцээгээ хангахын тулд хаа нэг газраас зээл авах шаардлага үүсэж байна. Үүнийг БЗС-аас олгох ОХЗ-д хамрагдан шийддэг олон оюутны жишээ энэ юм.

## IV. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нийт судалгаанд оролцогчдын 23% нь ОХЗ-ийн талаар маш сайн мэддэг, 46.1% нь сайн мэддэг 25.8% нь дунд зэрэг мэддэг бол үлдсэн 5.1% нь муу мэдэх буюу мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс үзэхэд ОХЗ-ийн талаарх дунд болон түүнээс дээших мэдлэгтэй оролцогчид тус судалгаанд хамрагдсан нь судалгааны үр дүн бодитой байх нөхцлийг бүрдүүлж байна.


ОХЗ олгохыг нийт судалгаанд оролцогчдын 99% нь зөв гэж үзэж байна. Учир нь энэ зээл оюутан суралцагчдыг өрийн дарамтгүй, хугацаа алдалгүй суралцах боломжийг бий болгож өгөх, дээд боловсролыг эзэмших боломжоор хангах зэрэг олон ач холбогдолтой гэдгийг эндээс харж болно.

ОХЗ-ийн хэрэгцээ нийт судалгаанд оролцогчдын 94.4%-д зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлсэн байна. Энэ нь тэдний суралцах боломжийг хангаж буй чухал хүчин зүйл болоод суралцах хэрэгцээнд зайлшгүй чухал нөлөөтэй гэж үзсэн.

Судалгаанд оролцсон нийт оролцогчдын 70.6% нь өөрөө болон ойр дотны хүн нь ОХЗ-д хамрагдаж байсан байна. Үүнээс үзвэл тус судалгааны үр дүнд оюутны хөгжлийн зээлийн ач холбогдлыг тодорхойлох, яагаад зээлд хамрагдаж буй шалтгаан, ОХЗ-ыг зогсоовол гарах сөрөг үр дүн зэргийг бодитой үнэлсэн байх магадлал өндөр юм.


Ар гэрийн байдлаас шалтгаалан сургалтын төлбөрөө төлөх ямар ч боломжгүй оюутан суралцагчид судалгаанд оролцогчдын 89.1%-ийг эзэлж байна. Өнөөдөр ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан суралцах хэрэгцээгээ хангаж чаддаггүй асар олон оюутан суралцагч байдаг. Ажлын байрны тавигдах шаардлага нь нэн тэргүүнд диплом шаардах өнөөгийн нөхцөлд дээд боловсрол эзэмших нь нэг номерын асуудал болоод байна. Тэгэхээр засгийн бодлого, ажиллагааны чиглэл нь иргэд олон нийтийн амжиргааны түвшинг сайжруулах гэж үзвэл оновчтой шийдэл нь боловсрол олгох юм. Одоо хангалттай хэмжээний боловсролоор бордож байж ирээдүйд ургац их хураах учиртай.

Зураг 3. ОХЗ-ийн ач холбогдлыг тодорхойлсон байдал



ОХЗ-ийн санхүүжилт зогсвол нэг хэсэг нь сургалтын төлбөрөө гэр бүлийн хэн нэгэн гишүүнээр зээл авахуулан зээлийн хүү төлж сурах нөхцөл байдал үүсэх ба нөгөө хэсэг нь сургууль завсардах сонголтыг сонгосон үзүүлэлттэй байна. Үлдсэн нь оюутан суралцагчид сургууль завсардах аль эсвэл ажил хийж олсон мөнгөндөө тааруулж цөөн кредитийн хичээл үзэж олон жил суралцах нөхцөл байдал руу шилжихээр байна. Энэ нь цаашлаад сургуулиа хаях эрсдлийг үүсгэж байгаа юм. Нийт ард иргэдийн зээлийн голлох шалтгаануудын дунд оюутан суралцагчийнхаа сургалтын төлбөрийг хийх зорилготой зээл их байна.

Зураг 2. ОХЗ-ийг зогсоовол сурах асуудлаа шийдвэрлэх байдал



Судалгаанд оролцогчид ОХЗ-ийн ач холбогдлыг өрийн дарамтгүй, хугацаа алдалгүй суралцах боломж гэж талаас илүү хэсэг нь үзсэн. Сургалтын төлбөрийн боломж бололцоо хомс байдлаасаа болж хагас улирал сураад үлдсэн хагаст нь өнжиж ажил хийх цикл газар аваад байгаа. Тэгвэл ОХЗ бий

болсноороо бид суралцах хугацаандаа суралцаж мэргэжил эзэмшин улсдаа хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ сургалтын төлбөрийн өрөө гүйцэлдүүлэх боломж бүрэн байна. Монголын нийгэмд 2 өрх тутмын 1 нь системд бүртгэгдсэн өртэй амьдарч байна. Тиймдээ ч өр, өрийн хүү, алданги гээд айдас ар араасаа цуварч бий болдгийг нуух юу билээ.

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 81.2% нь ОХЗ-ийн ач холбогдлыг хамгийн их утга буюу 5 оноогоор үнэлсэн байна. Үүнээс үзэхэд оюутан суралцагчдын дунд оюутны хөгжлийн зээлийн хэрэгцээ шаардлага өндөр буюу зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

## Ⅴ. ДҮГНЭЛТ

Улс эх орныхоо хөгжлийн түүчээ болсон оюутан залуусынхаа суралцах чин хүсэл, эрмэлзлэлийг үнэлэн ойшоож суралцах хэрэгцээг ханган сургалтын төлбөрийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, тэгш боломжоор хангах нь ирээдүй хойчдоо үнэтэй хөрөнгө оруулах оновчтой шийдэл билээ. Оюутан суралцагчдын тодорхой хувь нь сургалтын төлбөрийн боломжгүйгээсээ болж дээд боловсрол эзэмшихэд хүндрэлтэй нөхцөл байдалд байна. Ард иргэдийн дийлэнх хувь нь дунджаас доогуур орлоготой ч тэдний сурч боловсрох хэрэгцээ их байна. Сурч боловсроход хамгийн том учирч буй саад нь сургалтын төлбөрийн асуудал юм. Санхүүгийн боломжгүйгээсээ үүдэн гадны улс оронд хар ажил хийн хөдөлмөрийн мөлжлөгт нэрвэгдэж байгаа нь нууц биш болсон. Учир нь эх нутаг нь аль ч ажлын местэндээ өнөөх л сургуулийн дипломоо шаарддаг. Хүн өөрийн сонирхол, үзэл бодолдоо тулгуурлан мэргэжил сонголт хийдэг. Тэгвэл суралцах хэрэгцээгээ хангахын тулд нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжлээ сонгоно гэдэг дургүйд хүчгүйгийн тод жишээ болох байлтай. Нөгөөтэйгүүр өөрийн хүсэл сонирхол дээр тулгуурлан мэргэжлээ сонгосон “эрэлтгүй” гэх тодотголтой оюутан залуус цаашид ар гэрийн боломжгүйн улмаас сургалтын төлбөрөө төлж чадахгүйд хүрч байна. Улмаар улс орны ажилгүйчүүдийн эгнээг тэлэх шалтгаан нэгээр нэмэгдэж байгаа нь энэ. Өрийн дарамтгүй, хугацаа алдалгүйгээр дэлхийн залуустай эн зэрэгцэн олон улсад болоод эх орондоо чанартай дээд боловсрол эзэмшиж улсдаа өөрсдийн үнэтэй хувь нэмрээ оруулах чин хүсэл эрмэлзэл байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Судалгаанд оролцогчдын 94,4 хувь нь ОХЗ зайлшгүй хэрэгцээтэй, энэ нь бидний суралцах хүсэл сонирхол, хэрэгцээг хангах үндсэн хүчин зүйл болдог гэжээ. *Тухайн судалгаанд тулгуурлан дэвшүүлж буй санал:*

- Төр засгийн зүгээс аливаа шийдвэр гаргахын өмнө судалгаа шинжилгээ хийж, үр дүнд үндэслэн шийдвэр гаргадаг байх, шийдвэрийн хэрэгжилтийг үнэлдэг байх, шийдвэр нь тодорхой хугацаанд тогтвортой үйлчилдэг байх

- “Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжил”-ийг дэлхий нийтийн жишгээр бус Монгол улсын нийгмийн хэрэгцээ шаардлагын хүрээнд түүнчлэн цаашдын 10-20 жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан тодорхойлох
- “Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжил” сонгон суралцаж буй оюутан суралцагчдад шалгуур үзүүлэлтийг багасган, бусад төрлийн мэргэжлийн оюутан суралцагчдын шалгуур үзүүлэлтийг өндөрсгөх. Ингэснээр тэргүүлэх чиглэлээр олон оюутан элсэн суралцаж, нийгэмд хэрэгцээтэй боловсон хүчин бэлтгэгдэх боломж бүрдэх учраас ийм нөхцлийг хангах
- Сурагчдад ЕБС-иас нь эхлэн нийгэм дэх олон мэргэжлийн тухай мэдлэг олгох, мэргэжил сонголт хийхэд чиг баримжааг таниулах
- Оюутны хөгжлийн зээл авч буй оюутан суралцагчдад БНСУ шиг санхүүгийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол явуулах
- Оюутны хөгжлийн зээлд хамрагдаж буй оюутан суралцагчдад нэг улиралд хэрэгжүүлэх нийгмийн сайн дурын ажлын цаг тогтоох
- Оюутны хөгжлийн зээлийн санхүүжилтийг төрөөс шат шатанд нь хянадаг байх
- Оюутны хөгжлийн зээлд хамрагдаж буй оюутан суралцагчдын зээлийн санхүүжилтийг хичээл сонголт хийх хугацаанаас өмнө шийдвэрлэх (ОХЗ-ээр суралцаж буй оюутнууд хичээл сонголт нь хоцорч улмаар хичээл сонголтын багш, цаг дүүрэх зэрэг тэгш бус байдлын асуудал үүсдэг).

### **НОМЗҮЙ**

[1] ЮНЕСКО. Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг уу?, УБ., 2015, х 39

[2] ЮНЕСКО. Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Боловсрол бүх нийтийн баялаг уу?, УБ., 2015, х 18

[3] Maslow, A. H. (1943). A Theory of Human Motivation. *Psychological Review*, x 375

[4] Maslow, A. H. (1954). *Motivation and personality*. New York: Harper and Row.

Maslow, A. H. (1962). *Toward a Psychology of being*. Princeton: D. Van Nostrand Company.

[5] ERG-Existence-оршин тогтнох, Relatedness-харилцан уялдаа холбоотой байх, Growth-өсөлт гэсэн утгыг илэрхийлдэг.

[6] Удирдлагын академи. Менежмент. УБ., 2017. х 370

[7]<https://www.worldbank.org/mn/country/mongolia/publication/mongolia-poverty-update>

ҮСХ. Дэлхийн банк. Ядуурлын дүр төрх судалгааны тайлан. УБ., 2018

[8] ҮСХ. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2020 оны 4-р улирлын танилцуулга. УБ., 2021. х 12

[9] Эх сурвалж: UN Committee on Economic, Social, Cultural Rights (CESCR). 1999. *General Comment № 13: The Right to Education (Art 13 of the Covenant)*, 8 December 1999. E/C.12/1999/10 (46/4), available at: [www.refworld.org/docid/4538838c22.html](http://www.refworld.org/docid/4538838c22.html) [Accessed 6 March 2015]

[10] Altbach, P. G., Reisberg, L. and Rumbley, L. E. 2009. *Trends in Global Higher Education: Tracking an Academic Revolution* («Дээд боловсролын салбарын ерөнхий чиг хандлага: боловсролд гарч буй хувьсгалыг шинжэх нь». ЮНЕСКО-ийн зохион байгуулсан Дээд боловсролын дэлхийн бага хуралд бэлтгэсэн илтгэл (2009 он).

[11]<http://www.moe.gov.cn/?fbclid=IwAR1tCwFK87VSGEsx2S8pj34J4PKzRWkhChsRx-T3CAD8GJJYU9c2QGv7ck>

- [12] <https://www.sciencedirect.com/science/article/pii/S027277571730691X>
- [13] [https://www.kosaf.go.kr/ko/tuition.do?pg=tuition\\_info&fbclid=IwAR2vbAdlpWjikeYhIwk\\_mawr\\_4NTh7yIm3a8nYwEIjhhrjSHSJ1kL7JO\\_\\_8](https://www.kosaf.go.kr/ko/tuition.do?pg=tuition_info&fbclid=IwAR2vbAdlpWjikeYhIwk_mawr_4NTh7yIm3a8nYwEIjhhrjSHSJ1kL7JO__8)
- [14] <https://www.legalinfo.mn/annex/details/7441?lawid=12193>
- [15] “NTV телевизийн Улаан Бал нэвтрүүлэг” БШУЯ-ны сайд Л. Энх-Амгалан
- [16] “Parlament телевизийн ТӨВ ЦЭГ ОНЦЛОХ МЭДЭЭ” БЗС-ийн захирал Ж. Ариунболд
- [17] [https://www.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_2001\\_015V2](https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2001_015V2)
- [18] <https://www.surveymonkey.com/mp/sample-size-calculator/>